



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/311

Булган сум

“Тэгш ургах” ХХК-тай гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Агт сумын халуун усны барилгын гадна цахилгааны нэмэлт ажилд 24,675,000 (хорин дөрвөн сая зургаан зуун далан таван мянга) төгрөгөөр “Тэгш ургах” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Нэмэлт санхүүжилттэй холбоотой бичиг баримтыг хүлээлгэн өгөхийг “Тэгш ургах” ХХК-ийн захирал (Г.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3.Баян-Агт сумын халуун усны барилгын гадна цахилгааны нэмэлт ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж, ашиглалтад оруулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Баян-Агт сумын халуун усны барилгын гадна цахилгааны нэмэлт ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

